



ДАРХАН-УУЛ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 01А/84

Дархан

Цагийн хуваарь батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.11 дэх заалт, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3, 19.1.12 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цахим тоглоомын газар, интернэт кафе болон барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний газрын ажиллах цагийн хуваарийг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү захирамжийг захиргааны ерөнхий хуульд заасны дагуу хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Л.Алтанчимэг)-д даалгасугай.

3.Холбогдох хууль, тогтоомж, стандартыг хангуулж, хяналт тавьж ажиллахыг Дархан сумын Засаг дарга (Т.Тулгаа), Орхон сумын Засаг дарга (Б.Түмэнцогт), Шарын гол сумын Засаг дарга (Б.Лхамсүрэн), Хонгор сумын Засаг дарга (Т.Атархишиг), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Д.Нацагдорж), аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбоотой аймгийн Засаг даргын "Цагийн хуваарь батлах тухай" 2023 оны 01/А/124 дүгээр захирамжийг хүчингүй болгосонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АЗЖАРГАЛ



Аймгийн Засаг даргын 2024 оны 01  
дугаар сарын 18 -ний өдрийн 01/А/184  
дугаар захирамжийн хавсралт

ЦАХИМ ТОГЛООМЫН ГАЗАР, ИНТЕРНЭТ КАФЕ БОЛОН БАРЬЦААЛАН  
ЗЭЭЛДҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН АЖИЛЛАХ ЦАГИЙН ХУВААРЬ

№	Үйл ажиллагааны нэр	Насны хязгаар	Улирлын онцлогоор ажиллах хуваарь	Үйл ажиллагаа явуулах цагийн хуваарь	
				Эхлэх цаг	Хаах цаг
1.	Цахим тоглоомын газар, интернэт кафе	10-18 хүртэлх насны хүүхдэд	04 дүгээр сарын 01-нээс 10 дугаар сарын 01 хүртэл	09:00	20:00
			10 дугаар сарын 01-нээс 04 дүгээр сарын 01 хүртэл	09:00	18:00
		Насанд хүрэгчдэд	Улирал харгалзахгүй	09:00	23:00
2.	Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ	Насанд хүрэгчдэд	Улирал харгалзахгүй	08:00	20:00

# ЦАГИЙН ХЯЗААР ТОГТООХ ТУХАЙ ЗАХИРАМЖИД ХИЙСЭН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2024 оны 04 дүгээр  
сарын 17-ны өдөр

Дархан

## 1. Захиргааны хэм хэмжээний акт гаргах үндэслэл, шаардлага, зорилт

### 1.1. Үндэслэл:

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.11, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3, 19.1.12 дахь заалтуудыг үндэслэв.

### 1.2 Шаардлага:

✓ Дархан-Уул аймагт 2022 онд 15 хүртэлх насны 24 хүүхдийн гэмт хэрэг үйлдсэн бол 2023 онд 64 болж өссөн байна. Цахим тоглоомын газрууд нь бэлэн мөнгөөр төлбөр авахаас гадна, иргэдийн эд зүйлс, бичиг баримтыг барьцаанд авч байгаа зэрэг нь өсвөр насны хүүхдүүдийг гэмт хэрэг үйлдэж мөнгө олох сэдлийг төрүүлээд зогсохгүй тоглох хүсэл зоригийг нь улам төрүүлж, мөнгө олохын тулд юуг ч хамаагүй хийхэд хүргэж байна. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор цахим тоглоомын газрын ажиллах цагийн хуваарийг насны ангиллаар ялгавартай зааж өгөх шаардлага үүссэн. 10-18 хүртэлх насны хүүхдэд үйлчлэхдээ улирлын байдлыг харгалзан цагийн хязгаарыг ялгамжтай зааж өгөх нь хүүхдийн гэмт хэрэг, зөрчилд өртөх, холбогдох эрсдэлийг бууруулах юм.

✓ Барьцаалан зээлдүүлэх төвийн хаах цагийг согтууруулах ундаагаар үйлчилдэг аж ахуй нэгж, байгууллагын хаах цагаас эрт тогтоож өгөх мөн гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг цагаас өмнө хаах байдлаар тогтоох нь аливаа эрсдэлийг бууруулах, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэх, цаашлаад аливаа гэмт хэрэг, зөрчилд холбогдох шалтгаан нөхцөлийг бууруулах ач холбогдолтой юм.

### 1.3. Зорилт:

Гэмт хэрэг зөрчлийн судалгаанд суурилан эрх ашиг, сонирхол нь хөндөгдөж буй бүлэг этгээдүүдийн саналыг үндэслэн аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд хатуу цагийн хуваарь тогтоож үйл ажиллагаанд нь саад хориг учруулалгүй хамгийн боломжит цагийн хязгаарыг тогтоох замаар Дархан-Уул аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах, урьдчилан сэргийлэх, иргэдийн амгалан, тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

## 2. Захирамжийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

### 2.1. Захирамжийн ерөнхий бүтэц:

Захирамжийн нэг дэх хэсэгт “Цахим тоглоомын газар, интернэт кафе болон барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний газрын ажиллах цагийн хуваарь”-ийг, хоёр дахь хэсэгт Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхийг үүрэг болгосон, гурав дахь хэсэгт холбогдох хууль, тогтоомж, стандартыг хангуулж, хяналт тавьж ажиллахыг үүрэг болгосон, дөрөв дэх хэсэгт уг захирамж гарсантай холбоотой аймгийн Засаг даргын “Цагийн хуваарь батлах тухай” 2023 оны 01/A/124 дүгээр захирамжийг хүчингүй болгосонд тооцохоор заасан.

### 2.2. Зохицуулж буй харилцаа нь:

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, цахим тоглоомын газар, барьцаалан зээлдүүлэх төвийн ажиллах цагийн хязгаарыг зохицуулна.

### **2.3. Хамрах хүрээ:**

Дархан-Уул аймгийн иргэд, цахим тоглоомын газар, интернэт кафе, барьцаалан зээлдүүлэх төвийн үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуй нэгж, байгууллага.

### **3. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийг тодорхойлох**

Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасны дагуу эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдүүдийг согтууруулах ундаагаар үйлчилдэг аж ахуй нэгж, байгууллага, иргэн гэж тодорхойлсон.

Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт зааснаар Захиргааны хэм хэмжээний актын төслийг аймгийн Засаг даргын тамгын газрын цахим хуудсанд 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн байршуулсан.

эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд сонсох ажиллагааг 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулж энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байгууллагуудын 20 төлөөлөл оролцсон.

Иргэдийн санаа бодлыг тусгах зорилгоор Googleforms программ ашиглан 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс 01 дүгээр сарын 24-ний өдрийн хооронд санал асуулга авахад 182 иргэн оролцсон.

### **4. Хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх:**

4.1 Интернэт кафе болоод цахим тоглоомын газрын аль алиных нь ажиллах цагийн хязгаарыг адил тогтоож өгсөн тул аж ахуй, нэгж байгууллагуудын хувьд аль нэг талд давуу байдал үүсгээгүй боловч насны ангиллаар үйлчилгээ үзүүлэх цагийн хязгаарыг ялгамжтай байдлаар тогтоосон. 10-16 хүртэлх насны хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор цагийн хязгаарыг улирлын онцлогийг харгалзан өвлийн улиралд 09:00-18:00 цаг хүртэл, зуны улиралд 09:00-20:00 цаг хүртэл байхаар тогтоосон. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй бүхий л барьцаалан зээлдүүлэх төвд энэхүү захирамж нь нэгэн адил үйлчлэх тул аль нэг талд давуу байдал үүсгээгүй.

4.2 Эрх ашиг, сонирхол нь хөндөгдөж буй бүлэг этгээдүүд дунд сонсох ажиллагааг зохион байгуулж тэдгээрийн саналыг үндэслэн аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд хатуу цагийн хуваарь тогтоож үйл ажиллагаанд нь саад хориг учруулалгүй хамгийн боломжит цагийн хязгаарыг тогтоож өгсөн. Ингэхдээ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд нийцүүлсэн.

4.3 Жендерийн эрх тэгш байдлыг хөндөөгүй.

4.4 Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэхгүй.

4.5 Барьцаалан зээлдүүлэх төвийн үйл ажиллагаа нь үнийн хөөргдөл бий болгоход нөлөөлөхгүй.

4.6 Зах зээлд шинээр орж ирж буй аж ахуйн нэгжүүдийн хувьд бэрхшээл, хүндрэлийг бий болгохгүй.

4.7 Төрийн байгууллага болон бусад иргэн, хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт ачаалал бий болгоогүй.

4.8 Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсооход хүргэхгүй.

4.9 Аж ахуй нэгж, байгууллагын ажиллах цагийн хязгаарыг уян хатан байдлаар тогтоож өгсөн тул эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй.

4.10 Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөхдөө хуульд заасан үндэслэлээр нөлөөлсөн.

4.11 Төрийн байгууллагаас цагийн хязгаарыг мөрдүүлж ажиллах талаар хяналт тавьж ажиллах бөгөөд хуульд нийцүүлэн боловсруулсан захиргааны хэм хэмжээний актыг мөрдүүлэх явцад хүнд суртал, авлига гарах нөхцөл байдал үүсэхгүй юм.

**5. Тухайн асуудлыг зохицуулж байгаа хүчин төгөлдөр хууль, захиргааны хэм хэмжээний акт байгаа эсэх:**

Аймгийн Засаг даргын “Цагийн хуваарь батлах тухай” 2023 оны 01/А/124 дүгээр захирамжаар зөвхөн цахим тоглоомын газар, барьцаалан зээлдүүлэх төвийн ажиллах цагийн хязгаарыг тогтоосон бөгөөд уг захирамжийг гаргахдаа захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагыг хангаагүй байх тул аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 01А/84 дүгээр захирамжаар дээрх захирамжийг хүчингүй болгосон.

**6. Актыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, техник, эдийн засгийн тооцоо:**

Холбогдох хууль, тогтоомж, стандартыг хангуулж, хяналт тавьж ажиллахыг Дархан сумын Засаг дарга /Т.Тулгаа/, Орхон сумын Засаг дарга /Б.Түмэнцогт/, Шарын гол сумын Засаг дарга /Б.Лхамсүрэн/, Хонгор сумын Засаг дарга /Т.Атархишиг/, Цагдаагийн газар (Д.Нацагдорж), аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад тус тус хариуцна.

БОЛОВСРУУЛСАН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН



Э.ХОНГОРЗУЛ

## ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮР ДҮНГ ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТАД ХЭРХЭН ТУСГАСАН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2024 оны 04 дүгээр  
сарын 17-ны өдөр

Дархан

Захиргааны ерөнхий хуулийн 32 дугаар зүйлд зааснаар захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал авах ажиллагааг 3 төрлөөр зохион байгуулж үр дүнг хуульд нийцүүлэн захиргааны хэм хэмжээний актад тусгасан. Үүнд:

**Санал авах ажиллагаа 1.** Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт зааснаар Захиргааны хэм хэмжээний актын төслийг аймгийн Засаг даргын тамгын газрын цахим хуудсанд 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн байршуулсан. Хуульд заасан 30 хоногийн хугацаанд цахим хуудсаар ямар нэг санал ирээгүй.

линк:<https://darkhan.gov.mn/wp/wp-content/uploads/2023/12/%D0%A2%D3%A9%D1%81%D3%A9%D0%BB-1.pdf>

**Санал авах ажиллагаа 2.** Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасны дагуу эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдүүдийг Дархан-Уул аймгийн иргэд, цахим тоглоомын газар, интернэт кафе, барьцаалан зээлдүүлэх төвийн үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуй нэгж, байгууллага гэж тодорхойлсон. Сонсох ажиллагааны талаарх мэдэгдлийг эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдүүдэд орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл (DBS tv)-ээр, Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудас (Дархан-Уул аймаг)-аар дамжуулж, мөн Дархан сумын Засаг даргын Тамгын газарт албан бичгээр хандаж Дархан сумын нутагт дэвсгэрт энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуй нэгж, байгууллагуудыг идэвхтэй хамруулах үүрэг чиглэл өгч ажилласан.

Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Нарийн бичгийн даргын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан хөтөлбөрийн дагуу 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдөр аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын зааланд эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж буй бүлэг этгээдүүдэд зохион байгуулж 20 аж ахуй нэгж, байгууллагын төлөөлөл оролцсон.

**Санал авах ажиллагаа 3.** Иргэдийн санаа бодлыг тусгах зорилгоор санал асуулга авах ажиллагааг иргэдийн хамгийн өргөн хэрэглэдэг цахим платформ болох фэйсбүүкт Дархан-Уул аймгийн албан албан ёсны хуудсаар 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс 01 дүгээр сарын 20-ны өдрийн хооронд “google form”-оор санал авч 182 иргэн оролцсон байна.

## Үр дүнг захиргааны хэм хэмжээний актад тугасан байдал

Санал авах чиглэл		Хэм хэмжээний актын төсөл	Хэлэлцүүлгийн үр дүн	Санал асуулгын үр дүн	Хэм хэмжээний актад туссан байдал
Цахим тоглоомын газар, интернэт кафе	Насны хязгаар	09-16 нас	10-18 нас	10-18 нас	10-18 нас
	04 дүгээр сарын 01-нээс 10 дугаар сарын 01 хүртэлх хугацаанд ажиллах цагийн хуваарь	09:00-20:00	09:00-20:00	10:00-19:00	09:00-20:00
	10 дугаар сарын 01-нээс 04 дүгээр сарын 01 хүртэлх хугацаанд ажиллах цагийн хуваарь	09:00-18:00	09:00-18:00	10:00-17:00	09:00-18:00
	Насанд хүрэгчдэд улирал харгалзахгүй үйлчилэх цагийн хуваарь	09:00-23:00	09:00-22:00	10:00-22:00	09:00-23:00
Барьцаалан зээлдүүлэх төвийн ажиллах цагийн хуваарь		08:00-20:00	08:00-20:00	09:00-20:00	08:00-20:00

МЭДЭЭЛЭЛ БЭЛТГЭСЭН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
МЭРГЭЖИЛТЭН




Э.ХОНГОРЗУЛ

## Санал авах ажиллагаа 2. Үр дүн


Нас

182 responses




Хүйс

182 responses



Цагийн хязгаар тогтоохыг дэмжиж байгаа эсэх


179 responses






### Цахим тоглоомын газар, интернэт кафены хүүхдэд үйлчлэх насны хязгаар

182 responses




### Цахим тоглоомын газар, интернэт кафены 04 дүгээр сарын 01-нээс 10 дугаар сарын 01 хүртэлх хугацаанд хүүхдэд үйлчилгээ үзүүлэх цагийн хязгаар

182 responses



### Цахим тоглоомын газар, интернэт кафены 10 дугаар сарын 01-нээс 04 дүгээр сарын 01 хүртэл хүртэлх хугацаанд хүүхдэд үйлчилгээ үзүүлэх цагийн хязгаар

182 responses



### Цахим тоглоомын газар, интернэт кафены насанд хүрэгчдэд үйлчилгээ үзүүлэх цагийн хязгаар

182 responses



### Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний газрын ажиллах цагийн хязгаар

182 responses

